

Боломж олгох ангиуд болон шилмэл дунд сургуулиуд

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Боломж олгох ангиуд гэж юу вэ?

Боломж олгох ангиуд нь оюун ухааны гоц авьяастай, өндөр чадамжтай 5 болон 6-р ангийн сурагчдыг хамруулдаг. NSW муж даяар нийт 87 сургуульд боломж олгох ангиуд (үүнд виртуал боломж олгох ангиуд орно) байдаг нь нийтийн боловсролын системийн нэг хэсэг нь болдог.

Шилмэл дунд сургуулиуд гэж юу вэ?

Шилмэл дунд сургуулиуд нь оюун ухааны гоц авьяастай, өндөр чадамжтай 7-12-р ангийн дунд сургуулийн сурагчдыг хамруулдаг. Нийт 17 бүрэн шилмэл сургууль, 26 хагас шилмэл сургууль, 4 хөдөө аж ахуйн шилмэл дунд сургууль (зарим нь дотуур байртай), мөн нэг виртуал шилмэл дунд сургууль тус тус байдаг.

Боломж олгох анги эсвэл шилмэл дунд сургуульд хамрагдахын давуу талууд юу вэ?

Судалгаагаар өндөр чадамжтай, гоц авьяастай сурагчдад сургалтын болон сайн сайхан байдлын тусгай хэрэгцээ байдаг нь тодорхойлогдсон. Боломж олгох анги болон шилмэл дунд сургуулиуд нь ижил чадамжтай хүүхдүүдийн хамтдаа суралцах, тэдэнд тохирсон сорилт бүхий сургалтын хөтөлбөрийг санал болгодог. Ижил чадамж бүхий бүлэгт хуваарилагдсанаар өндөр чадамжтай, гоц авьяастай олон хүүхдүүд өөрсдийгөө бусдад ойлгогдсон, мөн тэдний нэг болсон мэт мэдрэмж төрүүлж байсан гэдгээ мэдэгдсэн.

Миний хүүхэд өндөр чадамжтай эсвэл гоц авьяастай эсэхийг би хэрхэн мэдэх вэ?

Өндөр чадамжтай эсвэл гоц авьяастай хүүхдүүдэд дараах шинжүүд ажиглагдах хандлагатай. Үүнд:

- нэн сониуч байх
- шинэ санаа, шинэ ур чадварыг хялбар бөгөөд хурдан эзэмшдэг
- ой санамж сайтай
- ээдрээтэй асуултууд асуудаг
- бүтээлч байх
- юмыг ээдрээтэй талаас нь бодох дуртай
- шинэ зүйлст суралцахдаа олон давтах шаардлагагүй байдаг
- өөрийн дурлаж, сонирхсон зүйлдээ өндөр анхаарал хандуулдаг

Хэрвээ та хүүхдэдээ дээрх шинжүүдээс олон илэрч байгааг анзаарвал элсэх өргөдөл гаргаж үзэхийг зөвлөж байна.

Сурагчид элсэлтийн шаардлагыг хэрхэн хангах вэ?

Сурагчид түвшин тогтоох шалгалтыг үнэ төлбөргүй өгнө.

Боломж олгох ангийн түвшин тогтоох шалгалт дараалсан гурван хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- уншлага
- математикийн дүгнэлт хийх ур чадвар
- сэтгэн бодох ур чадвар.

Шилмэл дунд сургуулийн түвшин тогтоох шалгалт дараалсан дөрвөн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- уншлага
- математикийн дүгнэлт хийх ур чадвар
- сэтгэн бодох ур чадвар
- бичих ур чадвар.

Шударга Хуваарилалт

Боловсролын Яам нийгмийн цөөнх бүлгүүдийн өндөр чадамжтай, гоц авьяастай сурагчдын төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор Шударга Хуваарилалт Жишгийг хэрэгжүүлсэн. Энэхүү жишгийн хүрээнд орон тооны тодорхой хувийг дараахиргэдэд зориулсан болно. Үүнд:

- Нийгэм-боловсролын давуу тал багатай нийгмийн бүлгээс гаралтай сурагчид
- Уугуул иргэдийн хүүхдүүд
- хөдөө орон нутаг болон алслагдмал бүсийн сурагчид
- хөдөлмөрийн бэрхшээлтэй сурагчид

Шударга хуваарилалтын журмын дагуу хандахад тусгай өргөдөл гаргах шаардлагагүй. Тухайн өргөдлийн маягт болон боловсролын яамны бусад өгөгдөл мэдээллийг ашиглан шударга хуваарилалтын аль нэг бүлэгт харьяалагдах сурагчдыг тодорхойлох болно. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах вэб хуудсаар авна уу. <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/fair-access>

Энэ шалгалтанд сурагчид бэлдэх хэрэгтэй юу?

Түвшин тогтоох шалгалт нь цээжлэх техник бүхий сургалтаар олж авах ур чадваруудаас илүү шүүмжлэлтэйгээр тунгаан бодох ур чадвар өндөртэй сурагчдыг тодорхойлдог. Сурагчид Боловсролын Яамны вэб хуудас дээрх түвшин тогтоох шалгалтуудыг харж шалгалтын форматтай танилцах хэрэгтэй. Энэхүү шалгалтанд эрчимжүүлсэн байдлаар бэлдсэнээр өндөр амжилт гаргадаг гэдгийг нотолсон баримт байхгүй гэдгийг эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.

Та өмнө нь авсан боломж олгох ангийн түвшин тогтоох шалгалтуудын мэдээллийг дараах вэб хуудсаар харна уу. <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/placement-test/opportunity-class-practice-tests>

Та өмнө нь авсан шилмэл дунд сургуулийн түвшин тогтоох шалгалтуудыг дараах вэб хуудсаар харна уу. <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/placement-test/selective-high-school-practice-tests>

Хэн өргөдөл гаргаж болох вэ?

- NSW муж дахь засгийн газрын болон засгийн газрын бус бага сургуулиудын сурагчид өргөдөл гаргах боломжтой.
- Боломж олгох ангид өргөдөл гаргахад сурагчид Австрали эсвэл Шинэ Зеландын иргэн, эсвэл Австралийн байнгын оршин суугч байх ёстой.
- Хэрвээ гэр бүл нь тухайн элсэлт авч буй цаг хугацаанд NSW мужид амьдарч байгаа бөгөөд уг сургуульд суралцах хугацааны туршид NSW мужид амьдрах төлөвлөгөөтэй бол бусад мужийн болон гадаадын сурагчид өргөдөл гаргах боломжтой.
- Гэр бүл нь байнгын оршин суух эрх авахаар өргөдлөө гаргасан бөгөөд байнгын оршин суух зөвшөөрөл нь хуваарилалтын үр дүн гарахаас өмнө олгогдоно гэсэн үндэслэл бүхий бичиг баримт Дотоод Хэргийн Яамнаас авсан тохиолдолд мөн өргөдөл гаргах боломжтой.

Өргөдөл хэзээнээс хүлээн авах вэ?

Боломж олгох ангид элсэх өргөдлийг сурагч 4-р ангид орох үед, шилмэл дунд сургуулийн өргөдлийг сурагч 5-р ангид ороход нь хүлээн авч эхэлнэ. Өргөдөлтэй холбоотой чухал он сар өдрүүд болон бусад мэдээллийг яамны дараах вэб хуудсаар авна уу. <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/application-process>

Би хүүхдээ элсүүлэхдээ хэрхэн өргөдөл гаргах вэ?

- Бүх өргөдлийг дараах линкээр онлайнар бөглөнө: <https://shsoc.education.nsw.gov.au/>
- Өргөдлийг Англи хэл дээр бөглөх ёстой.
- Эцэг эхчүүд боломж олгох ангитай хоёр хүртэлх тооны сургууль, мөн гурав хүртэлх тооны шилмэл дунд сургуулийн хүсэлт гаргах боломжтой. Сонголтуудаа өргөдөлдөө өөрийн хүссэн дарааллаар нь жагсаан бичих ёстой. Хэрвээ сурагч нэгээс олон сургуульд тэнцвэл түүнд эхний сонголтын сургуулиас нь урилга ирэх болно.
- Хөдөлмөрийн бэрхшээлтэй эцэг эхчүүдэд онлайн өргөдлийг бөглөхөд бэрхшээлтэй байгаа бол Өндөр Үзүүлэлттэй Сурагчдын Багтай 1300 880 367 дугаараар холбогдон тусламж аваарай.
- Өргөдөл илгээхэд эсвэл түвшин тогтоох шалгалт өгөхөд үнэ төлбөргүй.

Боломж олгох ангиуд болон шилмэл дунд сургуулиуд хаана байдаг вэ?

Боломж олгох ангиуд нь NSW мужийн бүхий л даяарх засгийн газрын сургуулиудад байдаг ба жагсаалтыг эндээс харна уу: <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/choosing-a-school/opportunity-classes#findoc>

Шилмэл дунд сургуулиуд нь NSW мужийн засгийн газрын сургуулиуд ба жагсаалтыг эндээс харна уу: <https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools/choosing-a-school/selective-high-schools#findshs>

Виртуал боломж олгох ангиуд болон виртуал шилмэл дунд сургууль

Хэрвээ та хөдөө орон нутаг эсвэл алслагдмал бүсэд амьдардаг бол таны хүүхэд Aurora College-д элсэх өргөдөл гаргах боломжтой. Энэхүү засгийн газрын сургууль нь виртуал боломж олгох ангиуд болон виртуал шилмэл дунд сургуультай.

Сурагчид орон нутгийнхаа улсын сургуульд яван, мөн онлайн хурлын системийг ашиглан боломж олгох анги эсвэл шилмэл дунд сургуулийн ангиудад хамрагдах боломжтой.

Боломж олгох ангиудтай сургуульд хамрагддаг эсвэл одоо байгаа боломж олгох ангиуд болон шилмэл дунд сургуулиудын элсэлтийн харьяа сургуулийн сурагчид Aurora College-д өргөдөл гаргах боломжгүй.

Дэлгэрэнгүй мэдээлэл хаанаас авах вэ?

- Өргөдөл гаргах тухай мэдээллийг дараах вэб хуудсаар авна уу.
<https://education.nsw.gov.au/schooling/parents-and-carers/choosing-a-school-setting/selective-high-schools>
- Өндөр Үзүүлэлттэй Сурагчдын Багтай холбогдоно уу.
Имэйл: ssu@det.nsw.edu.au
Утас: 1300 880 367
- SHS Facebook: <https://www.facebook.com/groups/772251106301086/>
- OC Facebook: <https://www.facebook.com/groups/159342048077050/>

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ таны холбоо барих хүсэлтэнд орчуулагч хэрэгтэй бол Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэл болон залгахыг хүссэн дугаараа мэдэгдээрэй. Оператор таны хүссэн дугаарт залган таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.